



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1367
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Г.БАЙГАЛ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Ганболдын Байгалийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Ганболдын Байгал Байгалийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Ганболдын Байгал Байгалийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



НИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Бие даан нэр дэвшигч : Ганболд овогтой Байгал

Ажил хэрэгч Улаанбаатар байгуулах үүднээс бизнест ээлтэй хотыг бий болгохын төлөө мөрийн хөтөлбөр боловсруулан ажиллана.

1. Нийслэлийн бизнесийн дата судалгаа, мэдээллийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.
2. Нийслэлийн бизнесийн датад суурилсан ухаалаг системийг бий болгож, бизнесийн байгууллагтай хамтран ажиллана.
3. Нийслэлийн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай нягт хамтран ажиллана.
4. Нийслэлд бизнес эрхлэх орчны иж бүрэн судалгааны ажлыг хийнэ.
5. Нийслэлд хөрөнгө оруулагчдийн форумыг жил бүр зохион байгуулна.
6. Нийслэлд хийж хэрэгжүүлэх концессийн төслүүдийн жагсаалт гаргаж, BOT, BOO нөхцөлөөр хөрөнгө оруулах концессийн ажил зохион байгуулна.
7. Нийслэлд хөрөнгө оруулагчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах журам боловсруулна.
8. Нийслэл хотод "Гарааны бизнес эрхлэгчид"-д зориулсан бизнес инкубатор төвийг байгуулан ажиллана.
9. Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих сан байгуулна.
10. Гараан бизнесийн санхүүжилтийн тэтгэлэгт хөтөлбөрийг олон улсын байгууллагуудын тусламж, дэмжлэгтэй байгуулна.
11. ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлийг шударга явагдах тогтолцоог бүрдүүлж, нийслэл хотод оногдох санхүүгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
12. ЖДҮХС-ийн сонгон шалгаруулалтад Нийслэлийн Худалдаа аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн холбоодыг оролцуулдаг болно.
13. Нийслэлд хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрийн кластер байгуулах ажлыг эхлүүлж, газар төлөвлөлт, ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ.
14. Нийслэл хотыг түшиглэн байгуулах Үйлдвэрлэл технологийн парк болон Эдийн засгийн чөлөөт бүсийн санал санаачилгуудыг дэмжин ажиллана.



15. Төрийн хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан, үе шаттай шийдвэрлүүлнэ.
16. Төрийг авилга, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах чиглэлд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж хяналт тавина.
17. Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд Нийслэлийн зүгээс хамтран ажиллах ажлыг эхлүүлнэ.
18. Нийслэлд цахим худалдаа хөгжүүлэх ажлыг эрчимжүүлж, судалгааны ажлыг эхлүүлнэ.
19. Цахим худалдаа хөгжих үндсэн нөхцөл болсон тээвэр логистикийн дэд бүтцийн судалгаа хийж, бизнесийн байгууллагуудыг хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.
20. Нийслэл хотыг түшиглэн кино үйлдвэр, энтертайнмент төв байгуулах ажлыг санаачлан, гадны хөрөнгө оруулалт татах чиглэлд төсөл боловсруулан ажиллана.
21. Инновацийн сан байгуулах замаар инновацийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, инновацийн шилдэг бүтээлд жил бүр олгодог шагнал бий болгоно.
22. Инновацийн олон улсын хэмжээний форумыг жил бүр зохион байгуулдаг болно.
23. Бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан байгуулах замаар бүтээлч салбар (Creative Industry)-ыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, бүтээлч үйлдвэрлэлийн салбарын шилдэг бүтээлд жил бүр олгодог шагнал бий болгоно.
24. Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын олон улсын хэмжээний форумыг жил бүр зохион байгуулдаг болно.

